



Доктор Т.Цэцэгмаа

Хураангуй

Сүүлийн жилүүдэд их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн тоо өссөөр байгаа хэдий ч тэдний ажил эрхлэлтийн түвшин харьцангуй доогуур байна. Нийт ажилгүйчүүд болоод бакалаврын зэрэгтэй төгсөгчдийн эзлэх хувийн жин нэмэгдэх төлөвтэй байна. Иймээс тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд их, дээд сургууль болон коллежид тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх, мөн төр засгаас анхаарал тавьж, дэмжлэг үзүүлэх явдал чухал байна.

Энэхүү илтгэлд дэлхийн болоод үндэсний хэмжээнд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий төлөв байдал, төгсөгчдийн ажил эрхлэлтийн өнөөгийн байдал, тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжийн талаар тусгасан болно.

Түлхүүр үг

Залуучуудын ажилгүйдэл, төгсөгчид, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин

Оршил

Аливаа улс орны нийгмийн бодлогын төвд байдаг асуудал бол хүн амын хөдөлмөр эрхлэлт, түүнийг дэмжих бодлого юм. Ялангуяа Монгол Улсын нийт хүн амын 58 хувийг 30-аас доош насныхан эзэлж байгаа ба үүний 21 орчим хувь нь 15-24 насныхан байгаа бөгөөд 2010 оноос “хүн ам зүйн цонх” тохиож, улмаар 2020 он хүртэл үргэлжлэх талаар эрдэмтэн судлаачид бичсээр байна. 2015 оны 10-р сарын хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын

статистикаас харахад, улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 20.1 мянга буюу 63.8 хувь нь 15-34 насны залуучууд байна¹. Иймээс залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс явуулах бодлого ухаалаг, зөв байх нь чухал.

Түүнчлэн улсын дунджаар ажилгүй арван хүн тутмын гурав нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой, хоёр нь бүрэн дунд боловсролтой байна. Хөгжиж буй ихэнх орнуудад гол төлөв боловсрол доогуур буюу боловсролгүй хүн ам ажилгүй байдаг бол манай улсад боловсролтой иргэд ажилгүй байх магадлал өндөр байна². Үүнийг сүүлийн жилүүдэд их дээд сургууль, коллеж төгсөгчдийн тоо нэмэгдэж байгаатай холбон тайлбарлаж болно. БШУЯ-ны гаргасан статистикаас харахад, улсын хэмжээнд нийтдээ жилд дунджаар 36 орчим мянган оюутан төгсөж байгаа ба тэдний 50 хүрэхгүй хувь нь ажлын байртай болдог байна. Энэ бол хангалттай хувь биш.

Иймээс энэхүү илтгэлээрээ залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал болоод төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг хэрхэн нэмэгдүүлэх арга замын талаар тусгахыг зорьсон болно.

Нэг. Дэлхий нийтийн Хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий төлөв байдал

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага(ОУХБ)-ын “Global

1 <http://www.1212.mn/>

2 <http://www.mol.gov.mn/uploads/short%20report.pdf/>
Ажиллах хүчний судалгааны 2013 оны 2 дугаар улирлын судалгааны товч танилцуулга, х.19

Employment Trends-2014” оны илтгэлээс харахад, дэлхийн нийтийн хэмжээнд ажилгүйдэл өмнөх жилүүдийнхтэй адил өсөлттэй байгаа ба ажлын байр бий болголт ихэнх бүс нутгийн хэмжээнд удаашралтай байна. 2012 онд ажилгүйдэл 4.2 саяд хүрсэн нь хямралын жилүүдийг эс тооцвол 2000 оноос хойшхи хамгийн өндөр өсөлт бөгөөд мөн онд ажил хайгчид 197.3 сая хүрчээ. 2013 онд ажилгүйдлийн тоо 5.1 сая байх төлөв ажиглагдаж байна. Үүнээс гадна дэлхийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр, дор хаяж 2017 он хүртэл 6 орчим хувь байх таамаглал гарч байна³. Ялангуяа 2013 оныхыг өмнөх онтой нь харьцуулахад ажилгүйдлийн түвшин хөгжсөн орнуудад, тэр тусмаа Европын холбооны улсуудад өндөр байхаар тооцоологдож байгаа нь Евро бүсийн орнуудын өр болоод банкны системийн хямралтай холбоотой. Түүнчлэн хүн ам ба хөдөлмөрийн нөөцийн өсөлт, эдийн засаг ба хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтүүдийн улмаас Зүүн өмнөд Ази, Номхон далай, Зүүн Ази, Латин Америк, Карибын тэнгисийн орнуудад ажилгүйдлийн түвшин өндөр байх төлөвтэй байна. Глобал түвшинд залуучуудын ажилгүйдлийн түвшин бага зэрэг буурах хандлагатай байна. Дэлхийн хэмжээний санхүүгийн хямралын жилүүдэд буюу 2007-2010 онд ажилгүй залуучуудын тоо жилд дунджаар 3.4 саяар өсч байсан нь олон улсын хөдөлмөрийн зах зээл дээр залуучуудын илүүдлийг бий болгосон. Харин 2015 оны залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын тайлангаас

харахад, 2012-2014 онд тэдний ажилгүйдлийн түвшин 13 хувьд орчимд тогтворжсон байна. Цаашлаад ажилгүй залуучуудын тоо бага зэрэг буурах хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, 2009 онд 76.6 сая залуучууд ажилгүй байсан бол 2014 онд 73.3 сая болж 3.3 саяар буурчээ⁴.

Дэлхийн хөдөлмөрийн зах зээлийн хандлагад гарч байгаа өөрчлөлтүүдийн нэг бол ажилгүйдэл зөвхөн хөгжиж буй улс оны хүрээнээс хальж хөгжингүй орнуудад тулгамдсан асуудал болж байна. Сүүлийн жилүүдэд, Евро бүсийн орнуудад эдийн засгийн хямралын улмаас ажилгүйдчүүд олноор бий болж, үүнээс үүдэн нийгмийн сөрөг үзэгдлүүд гарч байна. Ажил хайгчдын өсөлтөд урт хугацаанд ажилгүй байсан хүмүүсийн эзлэх хувийн жин нэмэгдэж байгаа дүр зураг ажиглагдаж байгаа юм. Энэ нь зарим улс орнууд цагаачлалын болоод нийгмийн бодлогодоо шинэчлэл хийсэн, улс орнуудын, тэр тусмаа хөгжингүй орнуудын эдийн засгийн хямралын мөчлөг богиноссон зэргээр тайлбарлаж болно.

Хоёр. Монгол улсын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий төлөв байдал

Монгол Улсын нийт хүн амын 65 орчим хувийг хөдөлмөрийн насны хүн ам эзэлж байгаагаас 57 хувь нь 15-34 насныхан, 31 хувь нь 35-49 насныхан, 12 хувийг 50-59 насныхан эзэлж байна. Мөн ЭЗИХА нийт амын 40.2 хувийг эзэлж байгаа ба түүний 7.9 хувь нь ажилгүй иргэд байна (Хүснэгт 1).

Хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий үзүүлэлтүүд, нийт дүнгээр мян.хүн

Хүснэгт 1.

		2011	2012	2013	2014	2015*
Хүн ам		2786.3	2839.7	2931.3	2995.9	-
Хөдөлмөрийн насны хүн ам		1798.4	1812.1	1937.1	1941.5	1977.9
Эдийн засгийн идэвхитэй хүн ам		1124.7	1151.1	1198.3	1205.6	1242.6
Ажиллагчдын тоо		1037.7	1056.4	1103.6	1110.7	1145.3
Ажилгүй иргэдийн тоо	Нийт	87.0	94.7	94.7	95.9	97.3
	Бүртгэлтэй	57.2	35.8	42.8	52.3	32.7
	Бүртгэлгүй	29.8	58.9	51.9	43.6	64.6

* 2015 оны эхний хагас жилийн байдлаар

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл, 2012-2015


3 Global employment trends 2013: Recovering from a second jobs dip /International Labour Office. Geneva: ILO, 2013, p. 31

4 Global Employment Trends for Youth 2015: Scaling up investments in decent jobs for youth/ International Labour Office. Geneva: ILO, 2015, p. 1

Харин статистикийн сүүлийн хоёр жилийн тоон мэдээллийн харьцуулалтаас харахад, улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны

түвшин болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин 0.7 пунктээр нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин 0.1 хувиар буурсан байна (Зураг 1).

Зураг 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд(хувиар)*




* Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны сар бүрийн бюллетень

2015 оны эхний хагас жилийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын судалгаанаас харахад, нийт ажилгүй иргэдийн 292 (0.9 %) нь магистр доктор, 8796 (28.3 %) нь дипломын болон бакалаврын, 1974 (6.4 %) нь тусгай

мэргэжлийн дунд, 2267 (7.3 %) нь техникийн болон мэргэжлийн, 14570 (46.9 %) нь бүрэн дунд, 2142 (6.9 %) нь суурь, 724 (2.4 %) нь бага боловсролтой хүмүүс, 292 (0.9 %) огт боловсролгүй иргэд эзэлж байна (Зураг 2).

Зураг 2. Ажилгүй иргэд, боловсролын түвшингээр



*Эх сурвалж. Хөдөлмөрийн яам. 2015 оны 7-р сарын хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал Нийт ажил хайгчдын дотор дээд боловсролтой иргэдийн эзлэх хувийн жин өсч байна. Тухайлбал, 2009 онд 17.5 % байсан бол 2011 онд 22.1 %, 2013 онд 27.6 хувь байна (ХЯ, ХСИ: Ажилд зуучлах үйлчилгээний мэдээллийн эмхэтгэл, 2013, х.26, 55).

Түүнчлэн 2011-2015 оны "Ажиллах хүчний судалгаа"-наас харахад, ажилгүйчүүдийн дотор дипломын болон бакалаврын зэрэгтэй иргэд 2011 онд -19.9 %, 2013 – 23.9 хувь байсан бол 2015

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломж

оны эхний улирлын байдлаар 25.2 хувь тус тус эзэлж байна. Эндээс харахад, ажилгүйчүүдийн дотор дипломын болоод бакалаврын зэрэгтэй ажилгүйчүүдийн эзлэх хувь өсөх хандлагатай байна.

Сүүлийн жилүүдэд төр засгаас хөдөлмөр эрхлэлтийн талаар идэвхитэй бодлого явуулах болжээ. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар хангах, тэдний цалин хөлс нь амьдрал ахуйд нь хүрэлцдэг болгох... нь гол зорилтын нэг байх болно” гэжээ. Энэ зорилтын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, идэвхижүүлэх зорилгоор Шинэчлэлий засгийн газар “Ажилтай, орлоготой Монгол хүн”, “Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Оюутны хөдөлмөр эрхлэлт ба цагийн ажлыг дэмжих” зэрэг 10 гаруй хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлээд байна.

Гэсэн хэдий ч ажилгүй иргэдийн тоо, ажилгүйдлийн түвшин дорвитой буурахгүй байна. Тэр тусмаа залуучуудын ажилгүйдлийн түвшин өндөр байна. Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 23.8 мянга буюу 61.1 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Гурав. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал

Манай улсын хүн амын 21,7 хувийг 15-24 насны залуучууд эзэлж байгаа ба тэдний 28,1 хувь буюу 175,0 мянга орчим нь 100-гаад төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллеж, МСҮТ-д суралцаж байна(Зураг 3, 4).



Дээрх хоёр зургаас харахад, хэдийгээр ИДСК-ийн тоо цөөрсөн ч тэдгээрт суралцагчдын тоо буураагүй байна. Ялангуяа төрийн өмчийн ИДСК-ийн тоо гурав дахин буурсан ч суралцагчдын тоо ялимгүй бууралттай харагдаж байна.

Сүүлийн гурван хичээлийн жилийн байдлаар аваад үзэхэд, их дээд сургууль, коллежийг жилд дунджаар 36 мянга орчим суралцагчид төгсөж байна. Гэтэл төгсөгчдийн 50 хүрэхгүй хувь нь ажлын байртай болдог байна. Тухайлбал, 2012-2013 оны хичээлийн жилд, нийт төгсөгчдийн 41.9 хувь нь ажлын байртай болжээ(Зураг 5).



*Эх сурвалж:Боловсролын салбарын 2010-2011, 2011-2012, 2012-2013 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэл

Ийнхүү боловсрол хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гадна МУИС, МУБИС зэрэг томоохон сургуулиуд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг бие дааж хийж олон нийтэд зарлажээ. Судалгааны үр дүнгээс харахад, МУИС-ийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 62 орчим хувь

байхад МУБИС-ийнх 88 хувьтай байна(МУИС-ийн төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл дэх хөдөлмөр эрхлэлтийн байдал – 2011, 2012; МУБИС - ийг 2012 онд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа). 2015 оны 6-р сард Дээд боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд Дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах төслийн хүрээнд хийгдсэн Төгсөгчдийн мөшгөх судалгаагаар судалгаанд хамрагдсан сургуулийн төгсөгчдийн 70 хувь нь ажил эрхэлж байгаа гэсэн үр гарсан байна. Энэ судалгаанд МУИС, Этүгэн ИС, ТТДС, Гурван Эрдэнэ ДС, Шинэ Анагаах ДС

хамрагдсан.

Улсын хэмжээнд 2013 онд анх удаа Хөдөлмөрийн судалгааны институтаас 2010/2011 оны хичээлийн жилийн хаврын улиралд их, дээд сургуулийг бакалаврын боловсрол, МСҮТ-ийг мэргэжлийн анхан болон тусгай дунд боловсрол эзэмшсэн төгсөгчөөс олон улсын жишгийн дагуу мөшгих судалгаа хийжээ. Энэ судалгааны дүнгээс харахад, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 81,1 хувьтай байна(Хүснэгт 2).


Хүснэгт 2. Төгссөний дараах хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал

	Төгсөгчдийн тоо	Ажлын туршлагатай төгсөгчийн тоо	Ажил хийж буй төгсөгч	Ажил хайгч	Суралцагч	Хөдөлмөр эрхлэлтийн хувь / нийт төгсөгчдөд эзлэх хувийн жин/
Бүгд	27025	22983	21907	5180	3087	81.1%
Эр	9671	8497	8305	2027	765	85.9%
Эм	17353	14486	13602	3153	2322	78.4%

Эх сурвалж: ХСИ. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, УБ. 2013, х. 5

Дээрх судалгааны дүнгээс харахад, төгсөгчдийн ажилд ороход хамгийн ихээр нөлөөлсөн хүчин зүйлсэд эзэмшсэн мэргэжил(18.2-20.5 %), төгссөн сургууль(13 %), ярилцлагын чадвар(12.4-13.1 %) хэмээн судалгаанд хамрагдагсад хариулжээ(Зураг 6).

Зураг 6. Ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлс



Түүнчлэн 2014 онд хийсэн Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд 2012/2013 оны хичээлийн жилд ИДСК төгсөгчид хамрагдсан бөгөөд хийт төгсөгчдийн 64.0 хувь нь ажил хийдэг, үлдсэн 36 хувь ажил хийгээгүй байсан⁵. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт тааруу байгаагийн нэг шалтгаан нь тэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд төдийлэн сайн оролцдоггүй явдал юм. Дээрх

⁵ Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөрийн судалгааны институт. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа 2014. УБ. 2015, х.6


Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломж

судалгаагаар нийт төгсөгчдийн 31.3 хувь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцож байсан бол үлдсэн 68.7 хувь оролцож байгаагүй тогтоогдсон. Нийт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсдын 41.6 хувь нь суралцаж байхдаа ажлын байран дахь хөтөлбөр буюу үйлдвэрлэлийн дадлагат, 29.6 хувь нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрт бэлтгэх, зөвлөгөө мэдээлэл өгөх сургалтад тус тус хамрагдсан байна. Хамгийн сонирхолтой нь 2013 онд ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалга 2012 онтой харьцуулвал 2,1 дахин өсчээ. Ийнхүү хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт тодорхой түвшинд байсаар байгаа атал ИДСК төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин хангалтгүй байгаа шалтгааныг тодруулах шаардлага байгааг харж болно. Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд 2015 оны 10 сард хийсэн Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны асуулгаар “Ажил олгогчдоос Монголын их, дээд сургуулиудын олгож буй хөтөлбөр, мэргэжил ажил олгогчдын шаардлагад нийцдэг эсэх”-ийг тодруулахад 56 хувь нь “Нийцдэг” гэсэн эерэг үнэлгээ өгсөн

бол 44 хувь нь “Нийцдэггүй” гэж үзсэн⁶.

Аль ч улс оронд дээд боловсролын байгууллагын өрсөлдөх чадварын нэг үндсэн шалгуур бол төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин байдаг. Иймээс улсын хэмжээнд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг жил бүр гаргадаг олон улсын жишиг түгээмэл байдаг. Тухайлбал, Их Британийн дээд боловсролын гаргасан статистикаар, 2012-2013 онд төгссөн оюутнуудын 92.1 хувь нь сургууль төгссөнөөсөө хойш 6 сарын дараа ажил эрхэлж байгаа эсхүл үргэлжлүүлэн суралцахаар болсон нь өмнөх онд 90,8 хувь байснаас өсчээ⁷.

240 мянга орчим төгсөгчдийн хариултаас харахад, ихэнх дээд боловсролын байгууллагын төгсөгчдийн ажил эрхлэлт 90-95 хувийн хооронд хэлбэлзэж байхад, 25 ИДС-ийн төгсөгчдийн ажил эрхлэлт 95 хувиас дээгүүр байна.



⁶ Дээд боловсролын шинэчлэлийн төсөл: Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан. IRIM, 2015, х. 22
⁷ <https://www.hesa.ac.uk/pr/3271-press-release-206>

Түүнчлэн Сингапурын боловсролын яамнаас 2013 онд төрөөс санхүүждэг их сургуулиудын 15,365 бакалаврын төгсөгчдөөс авсан судалгааны дүнгээс харахад, тэдний ажил эрхлэлтийн түвшин 86.5-100 хувь байна⁸.

Дүгнэлт

1. Дэлхий нийтийн хэмжээнд ажилгүйдэл нэмэгдэж байгаагийн дотор залуучуудын ажилгүйдлийн түвшин харьцангуй өндөр байх төлөвтэй байна.
2. Манай улсын хүн амын дийлэнхийг 35 хүртэлх насны залуучууд эзэлдэг ба нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 60 гаруй хувийг эзэлж байна.
3. Ажилгүй иргэд болоод ажил хайгчдын дотор дипломын болоод бакалаврын боловсролтой ажилгүйчүүдийн эзлэх хувь өсөх хандлагатай байна. Дэлхийн улс орнуудын хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий төлөв байдлаас харахад, хөгжиж буй ихэнх орнуудад гол төлөв боловсрол доогуур буюу боловсролгүй хүн ам ажилгүй байдаг нийтлэг дүр зураг байдаг бол манай улсад эсрэгээр боловсролтой иргэд ажилгүй байх магадлал өндөр байна.
4. Төрөөс дээд боловсролын салбарт явуулж буй бодлогын үр дүнд их дээд сургууль, коллежийн тоо эрс буурч байгаа ч суралцагчдын тоо төдийлэн буурахгүй байна.
5. ИДСК төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин хангалтгүй байгаагийн зэрэгцээ улсын хэмжээнд судалгааны нэгдсэн аргачлал байхгүй, байгаа тоо баримтууд нь хоорондоо зөрүүтэй, шалтгаан нь тодорхойгүй, үндэслэл нотолгоо муутай байна.
6. ИДСК төгсөгчдөө хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамруулах, элсэхээс эхлээд оюутнууддаа ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажил олгогчийн зүгээс тавьж буй шаардлагад нийцүүлэн хөтөлбөрөө шинэчлэх, дээд боловсролын байгууллагууд аж үйлдвэрүүдтэй түншлэлээ хөгжүүлэх замаар төгсөгчдөө ажилтай болгоход ихээхэн анхаарч, идэвх санаачилга гарган ажиллаж чадвал тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломж байна.

Санал зөвлөмж

1. Төрөөс засгаас хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээрх төсөл

⁸<http://www.moe.gov.sg/education/post-secondary/files/ges-nus.pdf>

- хөтөлбөрүүдийн зорилго, хамрах хүрээг өргөтгөн, улмаар төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглүүлэх.
2. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны нэгдсэн аргачлалыг бий болгон, улмаар олон улсын туршлагаас суралцах байдлаар ИДСК бүр өөрсдийн төгсөгчдийн судалгааг үнэн зөв, бодитой гарган авч, сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх.
3. Ажил олгогчдоос төгсөгчдийн талаарх сэтгэл ханамжийн судалгаа тогтмолжуулан авч, тэдэнтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар ИДСК-ууд хичээлийн хөтөлбөрөө сайжруулах.
4. ИДС-дын дэргэд байгуулагдсан Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний төвийн чадавхийг бэхжүүлэх замаар элсэгчид төгсөгчдөд ажил мэргэжлийн баримжаа олгох болон хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээгээр хангах.
5. Салбарын яам хоорондын уялдаа холбоог сайжруулах. Ингэснээр эдийн засагт шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх чиглэлийг илүү дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг нийцүүлэхэд анхаарах.

Ашигласан материалын жагсаалт

1. ҮСХ. Монголын Статистикийн эмхэтгэл, 2005-2014
2. Дэлхий өрсөлдөх чадварын тайлан: Монгол Улс, 2012, 2013, 2014
3. ҮСХ, Ажиллах хүчний судалгаа, 2011-2015
4. БШУЯ, Боловсролын Статистик (хичээлийн жилээр), 2005-2015
5. ММСС. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, 2012
6. Монгол Улсын Хөдөлмөрийн яам. Хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын тайлан 2012-2015
7. Монгол Улсын Хөдөлмөрийн яамны харьяа ХСИ, Барометрийн судалгаа. УБ. 2012, 2013, 2014
8. ХСИ. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны тайлан. УБ, 2013, 2015
9. БШУЯ, АХБ, Ай Эйр Ай Эм судалгааны хүрээлэн. Дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах төслийн судалгааны тайлангууд. УБ. 2015
10. Global employment trends 2013: Recovering from a second jobs dip /International Labour Office. Geneva: ILO, 2013
11. Global Employment Trends 2014 Risk of a jobless recovery?, ILO. Geneva, 2014
12. Global Employment Trends for Youth 2015: Scaling up investments in decent jobs for youth/ International Labour Office. Geneva: ILO, 2015